

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

“АДУУНЧУЛУУН” ХК

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу “Адуунчулуун” ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан болно.

Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Үнэлгээний аргачлал

- Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2,
- Хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан бол 1
- Үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- Авбал зохих нийт онооны 90% болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй
- 70-89% байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсэж болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх
- 50-69% байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9		90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		66%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83%
5	Эрсдэлийн удирдлага	8	6		75%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		66,6%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	4		50%
8	Компанийн соёл	6	6		100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	7		70%
	Нэгдсэн дүн	78	55		75,9%

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт						
"Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ. Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтоон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодексг дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.						
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ						
Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна						
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь	Хариуцах эзэн
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, харнуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжсэн	ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланг хавсаргав.	2	100%	-
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулах, томилох асуудлыг компанийн дүрэм болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулж байгаа бөгөөд Залгамж халааны бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан.	1	50%	Нэр дэвшүүлэх хороо
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны	Хэрэгжсэн	2022 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд тусгагдсан бөгөөд 2023.04.26-ны өдрийн ХЭЭХ-д нийт хувьцаа эзэмшигчдэд тогтмол танилцуулж хэвшсэн.	2	100%	А.Оюун-Эрдэнэ

4	тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна. 1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Хэрэгжсэн	Компанийн дүрмийг хавсаргав.	2	100%	-
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	ТУЗ-ийн гишүүд нь анх томилогдохдоо Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байдаг ба цаашид компанийн үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай мэдлэг мэдээллийг олж авах, ур чадварыг олгох сургалтуудад хамруулах талаар 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан.	1	50%	Нэр дэвшүүлэх хороо, ТУЗ-ийн НБДарга
6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Хэрэгжсэн	ТУЗ нь 2022.03.03-ны №22/02 тоот тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна.	2	100%	-
ДҮН				10	83%	
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ						
Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ						
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	1. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, комплайнсын ажилтны мэдээллийг хавсаргасан анкетын дагуу хавсаргав. 2. ТУЗ-ийн Аудитын хорооны 2022 оны ажлын тайланг хавсаргав.	1	50%	-

8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг хавсаргав	2	100%	Аудитын хороо
9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжсэн	Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг хавсаргав.	2	100%	Цалин урамшууллын хороо
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжсэн	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг хавсаргав.	2	100%	Нэр дэвшүүлэх хороо
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэрэгжсэн	ТУЗ-ийн дэргэд Аудит, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын байнгын хороод ажилладаг. Компанийн бүтэц, үйл ажиллагааны цар хэрэгнээс хамаарч энэ бүтцийг боломжтой гэж үзэж байгаа болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тус тусдаа үйл ажиллагааны журамтай. Хороодыг ажлын туршилагатай, ур	2	100%	

			чадвартай, мэргэшсэн хүмүүсээр бэхжүүлэн ажиллаж байна.		
ДҮН				9	90%
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	Компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналыг хангах чиглэлээр холбогдох дотоод журмыг ТУЗ-ийн 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан	1	50%
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	Кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн цахим хуудсанд 2023.06.10-ны дотор байршуулна.	1	50%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэрэгжсэн	Байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйл, эрсдэлийн талаарх санхүүгийн бус мэдээллийг компанийн цахим хуудсанд тухай бүр байршуулдаг. Улирал бүр маягтын дагуу мэдээллэдэг.	2	100%
ДҮН				4	66%
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саалгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Хэрэгжсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг хавсаргав.	2	100%

16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэрэгжсэн	Хөндлөнгийн аудиторын дүгнэлт, түүнийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд оруулж ХЭ-ийг энэ чиглэлийн мэдээллээр хангаж хэвшсэн ба орон нутагт хөндлөнгийн аудитын компани байхгүй учир аудитын хороо хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг.	2	100%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	Дотоод хяналтын бүрэлдэхүүнийг шинэчлэн чиг үүргийг боловсруулан ажиллаж байна. 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд болон цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.	1	50%
ДҮН				5	83%
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэрэгжсэн	ТУЗ-ийн 2022.10.19-ний 22/14 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар Эрсдэлийн удирдлагын журам баталж, хэрэгжүүлж байна. /Журмыг хавсаргав./	2	100%
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар	Хэрэгжсэн	Компанийн хувьд эрсдэлийн удирдлагыг өнөөдрийн байдлаар аудитын хороо хяналт тавьж ажиллаж байгаа ба компанийн хувьд ТУЗ-дөө эрсдэлийн удирдлага хариуцсан тусдаа хороо байх шаардлагатай эсэхийг судалж байна. Эрсдэлийн талаар түүнийг хэрхэн удирдаж байгаа талаар компанийн үйл ажиллагааны тайлан, цахим	2	100%

	дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.		хуудас зэргээр дамжуулан нийтэд мэдээлж байгаа болно.		
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн харуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжсэн	Эрсдэлийн үнэлгээг үнэлгээний компаниар хийлгэж хяналтын байгууллагуудад хүргүүлдэг.	2	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Байхгүй.	Комплайнсын хяналтын холбогдох баримт бичгийг баталж, бүтэц, бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг судалж байгаа.	0	0%
ДҮН				6	75%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хэрэгжсэн	КтХ-62.1.13-т заасны дагуу 2023.04.26-ны өдрийн ХЭЭХ-д оруулж батлуулсан.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	Цалин урамшууллын хорооны 2023-2024 оны ажлын төлөвлөгөөнд цалин урамшууллын бодлогын баримт бичиг боловсруулахаар тусгагдсан.	1	50%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	2022 оны жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаарх мэдээллийг 2023.06.10 өдрийн дотор	1	50%

		компанийн цахим хуудсанд байршуулна.	4	66,6%
ДҮН				
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ				
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ				
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжээгүй	Бодлогын баримт бичигтэй болно.	0 0%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэрэгжээгүй	2023 оны жилийн үйл ажиллагааны тайлангаас эхлэн уг асуудлыг тусгана.	0 0%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжсэн	http://aduunchuluun.mn Компанийн цахим хуудас ажилладаг.	2 100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжсэн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийн дагуу Компани нь Хөдөлмөрийн дотоод журам болон Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.	2 100%
ДҮН				
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ				
			4	50%

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжсэн	Ёс зүйн дүрмийг ТУЗ-ийн 2022.10.19-ний өдрийн 22/14 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлан хэрэгжүүлж байна. /Хавсаргав/	2	100%
30	8.2. Алнваа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Хэрэгжсэн	Ёс зүйн дүрмийг ТУЗ-ийн 2022.10.19-ний өдрийн 22/14 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлан хэрэгжүүлж байна	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангил байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжсэн	Ёс зүйн дүрмийг ТУЗ-ийн 2022.10.19-ний өдрийн 22/14 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлан хэрэгжүүлж байна	2	100%
ДҮН				6	100%
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Хэрэгжсэн	Веб сайт: aduunchuluun.mn сайтаар тогтмол мэдээлдэг	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Зарим асуудал хэрэгжиж байгаа	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг боловсруулж 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан.	1	50%

34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжсэн	КтХууль, компанийн дүрэм, СЗХ-ы 45, 225, 377 тоот тогтоолд тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	2	100%
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжсэн	КтХууль, компанийн дүрэм, СЗХ-ы 45, 225, 377 тоот тогтоолд тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зорчигдохөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зорчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	хэрэгжээгүй	Холбогдох журмыг баталж, 2023-2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан	0	0%
ДҮН НЭГДСЭН ДҮН				7	70%
				55	75,9%

Санамж:
 "МХБ" ХК-ийн 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.
 Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хоронго оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

А.Оюун-Эрдэнэ

А.Оюун-Эрдэнэ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:
 ТУЗ-ийн дарга

Б.Шатар

Б.Шатар

2023.05.01